



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 26 өдөр

Дугаар А/283

Мандалговь

Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах
тусгай зөвшөөрөл сунгах тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 10 дугаар зүйлийн 10.1.1, 16 дугаар зүйлийн 16.2.2 дэх заалт, эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох салбар комиссын 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагуудын тусгай зөвшөөрлийг хавсралтад зааснаар сунгасугай.

2. Эрүүл мэндийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS5203:2002, Ахуйн шавьж мэрэгч устгах, халдваргүйжүүлэлт, үйлчилгээ MNS5161-3:2002 өөрсдийн үйл ажиллагаанд холбогдох бусад стандартын хэрэгжилтийг хангаж ажиллахыг эмнэлгийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг тусгай зөвшөөрөл олгох салбар комисс (А.Нарантуяа)-д, Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс) -т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210000

Аймгийн Засаг даргын 2021 оны...-р
сарын...-ны өдрийн... дугаар
захирамжийн хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ БАЙГУУЛЛАГЫН
НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

№	Үүсгэн байгуулагчийн нэр	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар	Тусгай зөвшөөрлийн хугацаа	Хугацаа
1	"Оточжой" ХХК	"Оточжой" хувийн эмнэлэг	Хүүхдийн өвчний оношлогоо, эмчилгээ	ЭХ-15/10/1025	5 жил	2021-07-09 2026-07-09
2	"Жас-Од" ХХК	"Шинэ-Од" шүдний эмнэлэг	Нүүр амны өвчний оношлогоо, эмчилгээ	ЭХ-15/10/1026	5 жил	2021-07-09 2026-07-09
3	"Наранбулаг" ХХК	"Наранбулаг" ариутгал халдваргүйтгэл	Ахуй шавьж мэргэч устгах, халдваргүйжүүлэх	АҮХ-15/10/1021	5 жил	2021-06-03 2026-06-03